

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

## СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь бүх нийтийн эрүүл мэндийг дэмжих, согтууруулах ундааны хор уршгаас хамгаалах зорилгоор стандартын шаардлага хангасан согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, үйлчлэх, импортлох, экспортлох үйл ажиллагааг согтууруулах ундааны эрэлт, нийлүүлэлт, хэрэглээг хязгаарлах замаар зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Согтууруулах ундааны хяналтын тухай хууль тогтоомж

2.1. Согтууруулах ундааны хяналтын тухай хууль тогтоомж нь энэ хууль, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн зарчим

3.1.Согтууруулах ундааны хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1.хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхийг архины шууд болон дам нөлөөллөөс хамгаалах, баталгаажуулах;

3.1.2.согтууруулах ундааны хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа бодитой байх;

3.1.3.согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, үйлчлэх үйл ажиллагаа эрхэлдэг, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийг согтууруулах ундааны хяналтын талаарх хууль тогтоомж санаачлах, хяналт тавих үйл ажиллагаанд оролцох болон нөлөөлөхийг хориглох;

3.1.4.согтууруулах ундаа үйлдвэрлэгч, импортлогчийн үйл ажиллагаанд урамшуулал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхгүй, татварын өршөөлд хамруулахгүй, бусад давуу тал олгохгүй, татварын хэмжээг бууруулахгүй байх;

3.1.5.согтууруулах ундааны хяналтыг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчилгүй хуулийн этгээд, олон нийтийн оролцоог дэмжих;

#### **4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

4.1.Уламжлалт, үйлдвэрийн бус аргаар сүүн бүтээгдэхүүнээр шимийн архи, айраг боловсруулах үйл ажиллагаанд энэ хуульд хамаарахгүй.

#### **5 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

5.1.Энэ хуульд заасан дараах нэр томьёогдор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“согтууруулах ундаа” гэж эм, эмнэлгийн зориулалтаас бусад хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн 2 хувиас дээш спиртийн агууламж бүхий ундааг;

5.1.2.“спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа” гэж 18 хувь хүртэл хүнсний этилийн спирт агуулсан согтууруулах ундааг;

5.1.3.“спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа” гэж 18 хувиас дээш хүнсний этилийн спирт агуулсан согтууруулах ундааг;

5.1.4.“согтууруулах ундааны хяналт” гэж согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа болон бусад этгээдийн үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох, дүгнэхэд чиглэсэн хянан шалгах, хариуцлага тооцох арга хэмжээний цогцолборыг;

5.1.5.“эрх бүхий улсын байцаагч” гэж Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3<sup>1</sup>.1.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуулиар эрх олгосон этгээдийг;

5.1.6.“согтууруулах ундааны зар сурталчилгаа” гэж согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээг дэмжихэд чиглэсэн аливаа хэлбэрийн мэдээлэл түгээх үйл ажиллагааг;

5.1.7.“орчны бүс” гэж согтууруулах ундааны үзүүлж байгаа эсхүл үзүүлж болзошгүй хор уршгийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, иргэдийн оролцоог өргөжүүлэх шаардлагыг харгалзан энэ хуульд заасан журмын дагуу тогтоосон тогтоосон газар нутгийг.

#### **6 дугаар зүйл.Согтууруулах ундааны хяналтын талаар төр, иргэн, хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүрэг**

6.1.Согтууруулах ундааны хяналтын талаар төрийн байгууллага дараах үүрэг хүлээнэ:

6.1.1.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Согтууруулах ундааны эрүүл мэндэд учруулах хор уршгаас сэргийлэх талаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн бус байгууллагын санаачилга, оролцоог дэмжих, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;

6.1.2.төрийн бүх шатны болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь бүрэн эрхийнхээ дагуу хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогын хүрээнд дангаар эсхүл холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах;

6.1.3.нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, олон нийтийн боловсрол олгох чиглэлээр согтууруулах ундаа үйлдвэрлэгч, импортлогч, худалдагч, үйлчлэгч эсхүл түүний ашиг сонирхлын төлөө ажиллаж байгаа хуулийн этгээд, иргэдтэй хамтран ажиллахаас татгалзах;

6.1.4.согтууруулах ундааны хяналтын талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа төрийн албан хаагч, бусад ажилтны ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж, хамтран ажиллахаас татгалзах;

6.1.5.согтууруулах ундааны хэрэглээг багасгах, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.

6.1.6.согтууруулах ундааны хяналтын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

6.1.7.согтууруулах ундааны хэрэглээний улмаас хүний эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэл, хор нөлөөний талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр иргэдийг хангах;

6.2.Согтууруулах ундааны хяналтын талаар согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ;

6.2.1.согтууруулах ундаа үйлдвэрлэгч болон түүний 20-иос дээш хувийн хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа, согтууруулах ундааны үйлдвэрлэлтэй холбоотой бусад мэдээллийг өөрийн цахим хуудаст байрлуулан нийтэд ил тод байлгах;

6.2.2.согтууруулах ундааны хор уршгаас сэргийлэх, бүх нийтийн эрүүл мэндийг дэмжих болон согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих;

6.2.3.согтууруулах ундааны хяналтын болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

6.3. Согтууруулах ундааны хяналтын талаар иргэн дараах үүрэг хүлээнэ.

6.3.1.согтууруулах ундааны хяналтын тухай хууль зөрчигчийн зөрчлийн талаар мэдээлэх;

6.3.2.согтууруулах ундааны хяналтын болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

## **7 дугаар зүйл.Согтууруулах ундааны төрөл**

7.1.Согтууруулах ундаа нь дараах төрөлтэй байна.

7.1.1.хүнсний зориулалтын спирт;

7.1.2.архи;

7.1.3.дарс;

7.1.4.ликёр;

7.1.4.шар айраг;

7.1.5.үйлдвэрийн аргаар боловсруулсан, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи;

7.1.6.2 хувиас дээш спиртийн агууламж бүхий коктейль.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ** **Согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл**

### **8 дугаар зүйл. Согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл, төрөл, олгох журам**

8.1.Согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.

8.2.Дараах аж ахуйн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхэлнэ.

8.2.1.согтууруулах ундаа үйлдвэрлэх

8.2.2.согтууруулах ундаа импортлох

8.2.3.согтууруулах ундаа худалдах

8.2.4.согтууруулах ундаагаар үйлчлэх

8.3.Энэ хуулийн 8.2.1, 8.2.2-т заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр Засгийн газар олгоно.

8.4.Энэ хуулийн 8.2.3, 8.2.4-т заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр сум, дүүргийн Засаг дарга олгоно.

8.5.Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ** **Согтууруулах ундаа үйлдвэрлэх**

### **9 дүгээр зүйл. Сонгон шалгаруултанд оролцогчдод тавигдах шаардлага**

9.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох этгээд дараах шаардлага хангасан байна;

9.1.1.стандарт,техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн үйлдвэрийн зураг, төсөв, төсөл боловсруулсан байх;

9.1.2.энэ хуулийн 9.1.1-д заасан төслийн талаар стандартчилал, хэмжил зүй, аймаг нийслэлийн онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, тэдгээрийн эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх;

9.1.3.согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох тэмдэгтийн хураамжийн 5 хувьтай тэнцэх хэмжээний дэнчин төлсөн байх;

9.1.4.татварын өргүй болох талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тодорхойлолт авсан байх;

9.1.5.тоолууржуулсан зориулалтын төхөөрөмжийн сонголт хийсэн байх.

## **10 дугаар зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг**

10.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

10.1.1.согтууруулах ундааны үйлдвэрийн төслийн баримт бичиг;

10.1.2.стандартчилал, хэмжил зүй, аймаг нийслэлийн онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, тэдгээрийн эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт;

10.1.3.тэмдэгтийн хураамжийн 5 хувьтай тэнцэх хэмжээний дэнчин төлсөн баримт;

10.1.4.татварын өргүй болох талаар татварын байгууллагын тодорхойлолт;

10.1.5.аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;

10.1.6.тоолууржуулсан зориулалтын төхөөрөмжийн танилцуулга;

## **11 дүгээр зүйл. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, олгох хугацаа**

11.1.Засгийн газар согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг дор дурдсан төрийн захиргааны байгууллагын санал, тэдгээрийн эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн, сунгаж, түдгэлзүүлж, хүчингүй болгоно:

11.1.1.татвар;

11.1.2.онцгой байдал;

11.1.3.мэргэжлийн хяналт;

11.1.4.стандартчилал, хэмжил зүй;

11.1.5.шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах.

11.2.Тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар олгож, ямар нэг зөрчил гаргаагүй тохиолдолд 2 жилийн мөн хугацаагаар сунгана.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасан байгууллагын аль нэг нь татгалзсан санал өгсөн бол тусгай зөвшөөрлийг сунгахгүй.

11.4.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түдгэлзүүлэх эсхүл сэргээх шийдвэр гаргана.

11.5.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан журмын дагуу хүчингүй болгоно.

## **12 дугаар зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага**

12.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах шаардлагыг хангасан байна:

12.1.1.үйлдвэрийн шаардлага

12.1.2.бүтээгдэхүүний шаардлага

12.2.Энэ хуулийн 12.1.1-д дараах шаардлага хамаарна.

12.2.1 Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн стандарт, техникийн зохицуулалтын;

12.2.2.технологийн горим, ариун цэвэр, эрүүл ахуйн;

12.2.3.үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, даралтат сав, хэмжих хэрэгсэл нь загварын туршилтад тэнцэж, бүртгэгдэн, баталгаажсан байх;

12.2.4.чанар, аюулгүй байдлын дотоод хяналт, удирдлагын;

12.2.5.үйлдвэрлэлийн дамжлагын болон түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний хяналтын итгэмжлэгдсэн сорилтын лабораторитой байх;

12.2.6.үйлдвэрлэлийн шугамын оролт, гаралтыг хянах зориулалт бүхий, хэмжлийн үр дүнг татварын байгууллагад шууд дамжуулах, тоолууржуулсан зориулалтын төхөөрөмжөөр тоноглогсон байх;

12.2.7.энэ хуулийн 12.1.6-д заасан тоолууржуулсан төхөөрөмж нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний спиртийн агууламж, тоо хэмжээ, нэр, төрөл, савалгаа, үйлдвэрлэсэн хугацаа, онцгой албан татварын тэмдгийн тоо, дугаарын мэдээллийг дамжуулах шаардлагыг хангасан байх;

12.2.8.үйлдвэрлэлийн шугам бүрэн битүүмжлэгдсэн, онцгой албан татварын тэмдгийг автоматаар наах зориулалтын төхөөрөмжөөр тоноглогдсон байх;

12.3. Энэ хуулийн 12.1.2-д дараах шаардлага хамаарна.

12.3.1.техникийн зохицуулалт, тохирлын гэрчилгээ авсан байх;

12.3.2.бүтээгдэхүүн, түүхий эд /спирт, зөөлрүүлсэн ус, буудай, соёолж, хөрөнгө, фермент, хүнсний нэмэлт зэрэг/-ийгитгэмжлэгдсэн сорилтын лабораториор шинжлүүлж, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх;

12.3.3.хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлсэн бүтээгдэхүүний нууцлалтай, зах зээлээс буцаах болон татан авах тогтолцоотой байх;

12.4.Согтууруулах ундааны үйлдвэрийн техникийн зохицуулалтын баримт бичгийг Стандартчиллын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн Засгийн газар батална.

12.5.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 4.1-г заасан болон согтууруулах ундааны төрөл, үйлдвэрлэх арга хэрэгсэл, түүхий эд, бүтээгдэхүүний нууцлал, үйлдвэрийн байршил, хүчин чадлыг заана.

### **13 дугаар зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид хориглох зүйл**

13.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэхтүсгай зөвшөөрөл эзэмшигчид дараах зүйлийг хориглоно.

13.1.1.тохирлын гэрчилгээгүй, мэргэжлийн хяналтын байгууллагын эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлтгүй согтууруулах ундааг нийлүүлэх;

13.1.2.хүнсний зориулалтын бус түүхий эдээр согтууруулах ундаа үйлдвэрлэх;

13.1.3.согтууруулах ундаанаас өөр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

13.1.4.түүхий эд, орц, найрлага, этилийн спиртийн агууламж зэргээр адил нэр төрлийн согтууруулах ундааг олон нэрээр үйлдвэрлэх;

13.1.5.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулах;

13.1.6.18 нас хүрээгүй хүн ажиллуулах;

13.1.7. тусгай зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах, түрээслэх, шилжүүлэх болон Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэл явуулж буй байршлаа өөрчлөх;

13.1.8. тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн аж ахуйн нэгжийн нэртэй ижил нэрээр нэрлэсэн согтууруулах ундаа үйлдвэрлэх;

13.1.9. Засгийн газрын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч хяналтын багцаа худалдах;

13.1.10. согтууруулах ундааг согтууруулах ундаанд ногдуулсан татвар болон үйлдвэрлэсэн өртгийн нийлбэр дүнгээс бага үнээр худалдах;

13.1.11. иргэдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх.

#### **14 дүгээр зүйл. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй компанийн нэгдэлд хориглох зүйл**

14.1. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн тухай хуулийн 6.13-т заасан компанийн нэгдэл болон түүний оролцогчид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшихийг хориглоно.

#### **15 дугаар зүйл. Спирт үйлдвэрлэх, хуваарилах**

15.1. Хүнс, санхүү, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тухайн жилд үйлдвэрлэх, хуваарилах спиртийн хэмжээг Засгийн газар тогтооно.

15.2. Спиртийг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн үйлдвэрлэх, хуваарилахыг хориглоно.

15.3. Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журмыг хүнсний, хууль зүйн, санхүү, эдийн засгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран боловсруулж, Засгийн газар батална.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

#### **Согтууруулах ундаа импортлох**

#### **16 дугаар зүйл. Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл**

16.1. Тухайн жилд импортлох согтууруулах ундааны нэр, төрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн согтууруулах ундааны олон улсын стандарт, дээд ангиллын зэрэг, хатуулгийг тусган Засгийн газар батална.

16.2. Энэ хуулийн 11.1-т заасан байгууллагын аль нэг нь татгалзсан санал өгсөн бол тусгай зөвшөөрлийг сунгахгүй.



16.3.Тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар олгож, зөрчил гаргаагүй тохиолдолд 2 жилийн хугацаагаар сунгана.

16.4.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түдгэлзүүлэх эсхүл сэргээх шийдвэр гаргана.

16.5.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөлд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.1-т заасан болон импортлох согтууруулах ундааны нэр төрлийг тусгана.

16.6.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан журмын дагуу хүчингүй болгоно.

**17дугаар зүйл.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага, бүрдүүлэх бичиг баримт**

17.1.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох этгээд дараах шаардлага хангасан байна.

17.1.1.согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл олгох тэмдэгтийн хураамжийн 5 хувьтай тэнцэх хэмжээний дэнчин төлсөн байх;

17.1.2.татварын өргүй болох талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тодорхойлолт авсан байх;

17.2.согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

17.2.1.стандартчилал, хэмжил зүй, аймаг нийслэлийн онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, тэдгээрийн эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт;

17.2.2.тэмдэгтийн хураамжийн 5 хувьтай тэнцэх хэмжээний дэнчин төлсөн баримт;

17.2.3.татварын өргүй болох талаар татварын байгууллагын тодорхойлолт;

17.2.4.аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;

17.3.Импортын согтууруулах ундаа дараах шаардлагыг хангасан байна.

17.3.1.импортлохыг зөвшөөрсөн согтууруулах ундааны жагсаалтад орсон байх

17.3.2.бүтээгдэхүүний дээжийг стандартчилал, мэргэжлийн хяналтын байгууллагаар урьдчилан шинжлүүлж, хилийн болон гаалийн эрүүл ахуйн хяналт шалгалтаар баталгаажуулсан байх;

17.3.3.хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлсэн бүтээгдэхүүний нууцлалтай, зах зээлээс буцаах болон татан авах тогтолцоотой байх;

17.4.Согтууруулах ундааг импортлохдоо олон улсын зэрэглэлтэй боомтоор, улсын хилээр нэвтрүүлнэ;

### **18 дугаар зүйл.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчид хориглох зүйл**

18.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.5, 13.1.7-13.1.10-д заасанхориглосон заалт нь согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчид нэгэн адил хамаарна.

18.2.Зорчигч хувийн хэрэгцээндээ зориулан 2 литрээс дээш согтууруулах ундаа улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

18.3.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч Компанийн тухай хуулийн 6.13-т заасан компанийн нэгдэл болон түүний оролцогчид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшихийг хориглоно.

### **19 дугаар зүйл.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөлтэй компанийн нэгдэлд хориглох зүйл**

19.1. Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч Компанийн тухай хуулийн 6.13-т заасан компанийн нэгдэл болон түүний оролцогчид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшихийг хориглоно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ** **Согтууруулах ундаа худалдах**

### **20 дугаар зүйл. Согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл**

20.1.Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл нь дараах төрөлтэй байна.

20.1.1.спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах;

20.1.2.спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах.

20.2.Сум, дүүргийн Засаг дарга согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг тухайн сум дүүргийн татвар, цагдаа, аймаг нийслэлийн онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, тэдгээрийн эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 20.1-т заасан төрөл тус бүрээр олгоно.

20.3.Энэ хуулийн 20.2-д заасан байгууллагын аль нэг нь татгалзсан санал өгсөн бол тусгай зөвшөөрлийг олгохгүй, сунгахгүй.

20.4.Энэ хуулийн 20.1.1, 20.1.2-т заасан тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар тухайн сум дүүргийн Засаг дарга олгоно.

20.5.Тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаанд зөрчил гаргаагүй тохиолдолд 2 жилийн хугацаагаар тухайн сум, дүүргийн Засаг дарга сунгана.

20.6.Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг тухайн сум дүүргийн цагдаа, онцгой байдал, татвар, мэргэжлийн хяналтын байгууллагын эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн үндэслэн сум, дүүргийн Засаг дарга түдгэлзүүлнэ.

20.7.Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан журам эсхүл тухайн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орчны бүсэд оршин суугч иргэдийн 50-аас доошгүй хувийн саналыг үндэслэн хүчингүй болгоно.

20.8.Энэ хуулийн 20.7-д заасан орчны бүсийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтооно.

### **21 дүгээр зүйл. Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага**

21.1.Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцогч энэ хуулийн 9.1.3-9.1.5-д зааснаас гадна дараах шаардлага хангасан байна:

21.1.1.стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулах байртай байх;

21.1.2.үйл ажиллагаа явуулах байрны талаар мэргэжлийн хяналтын байгууллагын эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх;

### **22 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг**

22.1.Тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хуулийн 11 дүгээр зүйл, энэ хуулийн 10.1.3-10.1.6-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

22.1.1.тухайн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын тогтоол, сум, дүүргийн татвар, цагдаа, аймаг нийслэлийн онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт;

22.1.2.үйл ажиллагаа явуулах байрны талаар мэргэжлийн хяналтын байгууллагын эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт;

### **23 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах цэг**

23.1.Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундааг дагнасан цэгт худалдана.

23.2.Согтууруулах ундаа худалдах дагнасан цэгийн тоо, байршлыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, орон сууцны хороолол, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан 2000 мянган хүн ам тутамд нэгээс ихгүй, 2000-аас доош хүн амтай суманд 2-оос дээшгүй байхаар тооцож сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтооно.

23.3. Энэ хуулийн 23.2-т заасан журмыг зөрчин тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.

23.4.Согтууруулах ундаа худалдах цэг дараах шаардлагыг хангасан байна:

23.4.1.үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан;

23.4.2.үйлчилгээний газрын гадна болон дотор талбайг хянах боломжийг хангасан камерын хяналтын тогтолцоог бүрдүүлсэн;

23.5.Согтууруулах ундаа худалдах дагнасан цэгт тавих нэмэлт шаардлагыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож болно.

#### **24 дүгээр зүйл.Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үүрэг, хориглох зүйл**

24.1.Согтууруулах ундааны худалдах тусгай зөвшөөрөл бүхий этгээд дараах үүргийг хүлээнэ.

24.1.1. техникийн зохицуулалт, тохирлын гэрчилгээ авсан согтууруулах ундаагаар үйлчлэх;

24.1.2.үйлчлүүлэгчээс иргэний цахим үнэмлэх эсхүл тухайн үйлчлүүлэгчийг 21 нас хүрснийг нотлох бусад бичиг баримт үзүүлэхийг шаардах;

24.1.3.согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдэд үйлчлэхгүй байх;

24.1.4.энэ хуулийн 24.2.2, 24.2.3-т заасан анхааруулгыг бусдад харагдахаар байрлуулах;

24.1.5.тухайн тусгай зөвшөөрөл эзэмших эрх бүхий этгээдэд ажиллаж буй ажилтнуудыг согтууруулах ундааны хууль тогтоомж, зөрчил, хариуцлагын сургалтад хамруулж, гэрчилгээ авсан байх

24.2.Энэ хуулийн 24.2.5-д заасан сургалтыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон сургалтын байгууллага зохион байгуулна.

24.3.Согтууруулах ундаа худалдахад дараах зүйлийг хориглоно:

24.3.1.энэ хуульд заасныг зөрчиж үйлдвэрлэсэн буюу импортолсон тохирлын гэрчилгээгүй, мэргэжлийн хяналтын байгууллагын эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлтгүй согтууруулах ундаа худалдах;

24.3.2.хяналтын шинжилгээ хийлгээгүй согтууруулах ундааг худалдах;

24.3.3.этилийн спирт худалдах;

24.3.4.согтууруулах ундаанд ногдуулсан татвар болон нийлүүлсэн үнийн нийлбэр дүнгээс бага үнээр худалдах;

24.3.5.тусгай зөвшөөрөлд зааснаас бусад газарт согтууруулах ундаа худалдах;

24.3.6.согтууруулах ундаа худалдах нэг тусгай зөвшөөрлөөр хоёр тусдаа үйл ажиллагаа явуулах;

24.3.7.дагнасан цэгээс бусад газарт спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах;

24.3.8.тусгай зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах, түрээслэх болон сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр худалдаа явуулж буй байраа бусдад түрээслэх, байршлаа өөрчлөх;

24.3.9.согтууруулах ундаа хэрэглэсэн эсхүл 21 нас хүрээгүй этгээдэд үйлчлэх;

24.3.10.согтууруулах ундаа худалдах цэгт 18 нас хүрээгүй хүн ажиллуулах;

24.3.11.согтууруулах ундааг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас согтууруулах ундаа худалдахыг хязгаарласан өдөр худалдах;

24.3.12.согтууруулах ундааг гар дээрээс, цахим хэлбэрээр, хүргэлтийн үйлчилгээгээр худалдах;

24.3.13.согтууруулах ундаа худалдах дагнасан цэгт согтууруулах ундаанаас өөр төрлийн бүтээгдэхүүн худалдах;

24.3.14.согтууруулах ундаа үйлдвэрлэх болон импортлох тусгай зөвшөөрөлгүй этгээдээс худалдан авах, дамжуулан худалдах.

## **25 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдахыг хориглох газар**

25.1.Дараах газарт согтууруулах ундаа худалдахыг хориглоно:

25.1.1.төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан болон үйлдвэрлэлийн байранд;

25.1.2.хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байр, эмнэлэг, сувиллын газар;

25.1.3.орон сууцны орц, хонгил;

25.1.4.орон сууцны оршин суугчид, өмчлөгчдөд зориулагдсан сууц өмчлөгчдийн холбооны орчны газар;

25.1.5.нийтийн эдэлбэрийн газар;

25.1.6.галт тэрэг, авто тээвэр, усан болон нисэх онгоцны буудлын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар;

25.1.7.үйлдвэрлэл, технологийн парк.

25.1.8.шатахуун түгээх газар;

25.1.9.хуульд заасан бусад

## **26 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарлалт**

26.1.Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундааг ням гарагт 10-18 цагт, бусад өдрүүдэд 10-21 цагийн хооронд худалдана.

26.2. Спиртийн сул агууламжтай согтууруулах ундааг 10-24 цагийн хооронд худалдана.

## **27 дугаар зүйл.Согтууруулах ундааг худалдахыг хориглох өдөр**

27.1.Тухайн орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал тухайн орон нутагт согтууруулах ундаагаар үйлчлэхгүй өдөр, цагийн хуваарийг энэ хуульд заасан хязгаарт багтааж тусгайлан тогтоож болно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ. Согтууруулах ундаагаар үйлчлэх**

## **28 дугаар зүйл.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл**

28.1.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл нь дараах төрөлтэй байна.

28.1.1.спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх;

28.1.2.спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх;

28.2.Сум, дүүргийн Засаг дарга согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг тухайн сум дүүргийн татвар, цагдаа, аймаг нийслэлийн онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, тэдгээрийн эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлт, орчны бүсэд оршин суугч иргэдийн иргэдийн 90-ээс дээш хувийн дэмжсэн саналыг үндэслэн энэ хуулийн 28.1-т заасан төрөл тус бүрээр олгоно;

28.3.Энэ хуулийн 28.2-д заасан байгууллагын аль нэг нь татгалзсан санал өгсөн бол тусгай зөвшөөрлийг олгохгүй, сунгахгүй;

28.4.согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар тухайн сум дүүргийн Засаг дарга олгоно;

28.5.Тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаанд зөрчил гаргаагүй тохиолдолд 2 жилийн хугацаагаар тухайн сум, дүүргийн Засаг дарга сунгана;

28.6.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх шийдвэрийг тухайн сум дүүргийн цагдаа, онцгой байдал, татвар, мэргэжлийн хяналтын байгууллагын эрх бүхий улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн 3 сар хүртэл хугацаагаар сум, дүүргийн Засаг дарга гаргана;

28.7.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан журам эсхүл тухайн согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орчны бүсэд оршин суугч иргэдийн 50-аас доошгүй хувийн саналыг үндэслэн хүчингүй болгоно;

28.8.Энэ хуулийн 28.1, 28.7-д заасан орчны бүсийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтооно;

### **29 дүгээр зүйл. Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага**

29.1.Сонгон шалгаруулалтад оролцогчид энэ хуулийн 9.1.3-9.1.6-д заасан шаардлагыг хангасан байна.

### **30 дугаар зүйл.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг**

30.1.Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 10.1.3-10.1.6-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

### **31 дүгээр зүйл.Согтууруулах ундаагаар үйлчлэх цэг**

31.1.Согтууруулах ундаагаар үйлчлэх цэг энэ хуулийн 23.4-т заасан шаардлагыг хангасан байна.

### **32 дугаар зүйл.Согтууруулах ундаагаар үйлчлэхэд хориглох зүйл**

32.1.Согтууруулах ундаагаар үйлчлэхэд энэ хуулийн 24.3.1-24.3.6, 24.3.8-24.3.13-т зааснаас гадна дараах зүйлийг хориглоно;

32.1.1.согтууруулах ундааг үйлчлэх цэгээс гадагш авч гарах зорилгоор худалдах

32.1.2.энэ хуулийн 25 дүгээр зүйлд заасан хориглосон газруудад согтууруулах ундаагаар үйлчлэх

### **33 дугаар зүйл.Согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаарлалт**

33.1.Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар 10-21 цагийн хооронд үйлчилнэ.

33.2.Спиртийн сул агууламжтай согтууруулах ундааг 10-24 цагийн хооронд үйлчилнэ.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ**

### **Согтууруулах ундааны хэрэглээнд тавих шаардлага**

#### **34 дугаар зүйл.Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох**

34.1.Дараах этгээд согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно:

34.1.1.21 насанд хүрээгүй;

34.1.2.жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эх;

34.1.3.албан үүргээ гүйцэтгэж яваа төрийн албан хаагч, хөдөлмөрийн болон бусад гэрээгээр ажил хөдөлмөр эрхэлж байгаа этгээд ажлын цагийн хугацаанд;

34.2.Энэ хуулийн 25 дүгээр зүйлд заасан газарт согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно.

34.3.Дараах хэлбэрээр согтууруулах ундаа хэрэглэх, хэрэглэх нөхцөл бүрдүүлэхийг хориглоно:

34.3.1.21 нас хүрээгүй хүнийг уруу татах, согтууруулах ундаа хэрэглэх боломж олгох, орон байраар хангах;

34.3.2.үнэгүй, урамшуулал хэлбэрээр тараах, цалин, хөлсийг орлуулж олгох;

34.3.3.төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авах.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ**

### **Согтууруулах ундааны хяналт**

#### **35 дугаар зүйл.Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн хяналт**

35.1.Согтууруулах ундааны үйлдвэрлэлд дараах байгууллага хяналт тавина:

35.1.1.согтууруулах ундааны үйлдвэрлэлд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн засаг дарга, стандартчилал, хэмжил зүйн, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;



35.1.2.бүтээгдэхүүний стандарт, чанар, аюулгүй байдалд мэргэжлийн хяналтын байгууллага;

35.1.3.согтууруулах ундааны үйлдвэрлэлд ногдох татвар, онцгой албан татварын тэмдгийн тооцоонд татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

35.2.Согтууруулах ундааны үйлдвэрлэлд хяналт тавих журмыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

35.3.Татварын болон стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд энэ хуулийн 9.1.6-д заасан тоолууржуулсан төхөөрөмж суурилуулах, түүнд хяналт тавих журмыг хамтран батална.

35.4.Согтууруулах ундааны үйлдвэрлэлд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтан нэн даруй биелүүлэх үүрэгтэй.

### **36 дугаар зүйл.Согтууруулах ундааны импортод тавих хяналт**

36.1.Согтууруулах ундааны импортод тавих хяналтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гаалийн болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хорио цээрийн хяналтын байгууллага, боомтын нэгдсэн захиргаа хэрэгжүүлнэ.

### **37 дугаар зүйл.Согтууруулах ундаа худалдах, үйлчлэхэд тавих хяналт**

37.1.Согтууруулах ундаа худалдах, үйлчлэхэд сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, баг, хорооны Засаг дарга, сум, дүүргийн цагдаа, мэргэжлийн хяналт, татварын байгууллага чиг үүргийнхээ дагуу хяналт тавина.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ**

### **Архины хор уршгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа**

### **38 дугаар зүйл.Согтууруулах ундааны сурталчилгааг хориглох**

38.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, үйлчлэх үйл ажиллагаа явуулж буй байгууллагыг дараах байдлаар сурталчилах, согтууруулах ундааны хэрэглээг дэмжихэд чиглэсэн бүх төрлийн мэдээлэл түгээхийг хориглоно;

38.1.1.согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, согтууруулах ундааны дүрс, тэмдэг, зураг, нэр, холбоотой үг хэллэгийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, интернэтээр, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз дээр болон бусад байдлаар;

38.1.2.согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг этгээд бүтээгдэхүүний зураг, нэр, барааны тэмдэг, компаний нэрийг сурталчлах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор шууд эсхүл өөр этгээдээр дамжуулан соёл, урлаг, спортын болон бусад олон нийтийн арга

хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх;

38.1.3.согтууруулах ундааны нэр, барааны тэмдэг зэрэг бусад ялгарах онцлогийг аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглах;

38.1.4.согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээг сурталчлах зорилгоор сугалаа, хонжвор, урамшуулалт худалдаа явуулах.

38.2.Согтууруулах ундааны зураг, нэр, барааны тэмдэг, зэрэг бусад ялгарах онцлогийг агуулсан аливаа хэлбэрийн зар сурталчилгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

### **39 дүгээр зүйл. Зөрчлийн талаар мэдээлэл авах**

39.1.Согтууруулах ундааг тусгай зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэсэн, улсын хилээр нэвтрүүлсэн, худалдсан, үйлчилсэн, энэ хуулиар хориглосон болон хуульд заасан шаардлагыг зөрчсөн зөрчлийн талаар мэдээллийг төрийн эрх бүхий байгууллага иргэнээс төлбөртэй авч болно.

39.2.Иргэнээс төлбөртэй мэдээлэл авахад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийг баримтална.

39.3.Төрийн эрх бүхий байгууллага мэдээлэл өгсөн иргэний аюулгүй байдлыг хангах үүднээс мэдээллийн эх сурвалжийг нууцлах үүрэгтэй.

### **40 дүгээр зүйл.Санхүүжилт**

40.1.Согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ, түүний хор уршгаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах, энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор архидан согтуурахтай тэмцэх сан, эрүүл мэндийг дэмжих сан ажиллана.

40.2.Архидан согтуурахтай тэмцэх сан, эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

## **АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **41 дүгээр зүйл.Гомдол гаргах**

41.1Согтууруулах ундааны хяналтын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас эрх, хууль ёсны ашигт сонирхолд нь хохирол учирсан гэж үзсэн иргэн, хуулийн этгээд гомдлоо холбогдох байгууллага албан тушаалтан болон шүүхэд гаргаж болно.

### **42 дугаар зүйл.Хураагдсан согтууруулах ундаанд шинжилгээ хийх, борлуулах, устгах**

42.1.Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, гааль, татвар, мэргэжлийн хяналтын албаны шийдвэрээр хураагдсан буюу шүүхийн шийдвэрээр хураахаар эцэслэн шийдвэрлэгдсэн согтууруулах ундааг улсын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийж, дараах дүгнэлтийн аль нэгийг гаргана:

42.1.1.эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, стандартын шаардлага хангасан тул хүнсэнд хэрэглэж болох;

42.1.2.техникийн болон хүнсний бус бусад зориулалтаар ашиглах боломжтой;

42.1.3.энэ хуулийн 42.1.1, 42.1.2-т заасан зориулалтаар ашиглах шаардлага хангахгүй, устгах.

42.2.Согтууруулах ундааг хураах, шинжилгээ хийх, улсын орлого болгож борлуулах журмыг Засгийн газар батална.

42.3.Энэ хуулийн 42.1.3-т заасан согтууруулах ундаа устгах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор хамтран батална.

### **43 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

43.1.Согтууруулах ундааны хяналтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараах хариуцлага ногдуулна;

43.1.1.согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, үйлчлэх үйл ажиллагаа эрхэлдэг, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийг согтууруулах ундааны хяналтын талаарх хууль тогтоомж санаачлах, хяналт тавих үйл ажиллагаанд оролцсон болон нөлөөлсөн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

43.1.2.Энэ хуулийн 13, 18, 24, 32 дугаар зүйлүүдэд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хууль бусаар олсон орлогыг хураана.

43.1.3.согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй Компанийн тухай хуулийн 6.13-т заасан компанийн нэгдэл болон түүний оролцогчид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

43.1.4.спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журмыг зөрчиж олгосон спиртээр согтууруулах ундаа үйлдвэрлэсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

43.1.5.энэ хуулийн 23.2-т заасан журмыг зөрчин тусгай зөвшөөрөл олгосон бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийг олгосон сум, дүүргийн Засаг даргыг огцруулах үндэслэл болно.

43.1.6.энэ хуульд заасан согтууруулах ундаа худалдах болон үйлчлэх цагийн хязгаарлалтыг зөрчсөн бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, хууль бусаар олсон орлогыг хураана.

43.1.7.өндөр агууламжтай согтууруулах ундааг дагнасан цэгээс бусад газар худалдаалсан бол хуулийн этгээдийн холбогдох тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хууль бусаар олсон орлогыг хураана.

43.1.8.согтууруулах ундааны зар сурталчилгааг захиалсан, бүтээсэн, мэдээлэх хэрэгслээр түгээсэн этгээдийн холбогдох тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

43.1.9.албан үүргээ гүйцэтгэж яваа төрийн албан хаагч, хөдөлмөрийн болон бусад гэрээгээр ажил хөдөлмөр эрхэлж байгаа этгээд ажлын цагийн хугацаанд согтууруулах ундаа хэрэглэсэн бол хөдөлмөрийн хуульд заасан ноцтой зөрчилд тооцно.

43.1.10.согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон этгээд хэрэглэсэн, хэрэглэх нөхцөл бүрдүүлсэн бол тухайн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

43.1.11.согтууруулах ундааны шошгыг дуурайлган үйлдэх, хууль бусаар хэрэглэсэн, худалдаалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгож, хууль бусаар олсон орлогыг хураана.

43.1.12.согтууруулах ундааг гар дээрээс, цахим хэлбэрээр, хүргэлтийн үйлчилгээгээр худалдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгож, хууль бусаар олсон орлогыг хураана.

#### **44дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

44.1.Энэ хуулийг 2014 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны . . . дугаар

Улаанбаатар

сарын . . . -ны өдөр

хот

### МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД

#### ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дах хэсгийг дор дурдсан байдлаар өөрчлөн найруулсугай.

35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“35.2.Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгахад дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

35.2.1.спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгох, сунгахад нийслэлд 50'000'000 төгрөг, аймгийн төвийн суманд 25'000'000 төгрөг, бусад суманд 15'000'000 төгрөг;

35.2.2.спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгох, сунгахад нийслэлд 20'000'000 төгрөг, аймгийн төвийн суманд 15'000'000 төгрөг, бусад суманд 5'000'000 төгрөг;

35.2.3.спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгахад нийслэлд 20'000'000 төгрөг, аймгийн төвийн суманд 10'000'000 төгрөг, бусад суманд 5'000'000 төгрөг;

35.2.4.спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгахад нийслэлд 12'000'000 төгрөг, аймгийн төвийн суманд 6'000'000 төгрөг, бусад суманд 4'000'000 төгрөг;

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны . . . дугаар сарын . . . -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**20.. оны . . . дугаар  
сарын . . . -ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны . . . дугаар сарын . . . -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны . . . дугаар  
сарын . . . -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ,ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл. Зар сурталчилгааны тухай хуульд дор дурдсан агуулгатай 14<sup>2</sup> дугаар зүйл нэмсүгэй:**

**“1/ 14<sup>2</sup> дугаар зүйл:**

14<sup>2</sup> дугаар зүйл.Согтууруулах эсрэг сурталчилгаа

14<sup>2</sup>.1. Хуульд өөрөөр заагаагүй бол согтууруулах ундааг дараах хэлбэрээр сурталчлахыг хориглоно:

14<sup>2</sup>.1.1.согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, интернэт, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар гаргах;

14<sup>2</sup>.1.2. 21нас хүрээгүй этгээдэд согтууруулах ундаа хэрэглэхийг зааж сургах;

14<sup>2</sup>.1.3.согтууруулах ундаа үйлдвэрлэгч нь өөрийн аж ахуйн нэгжийн нэртэй ижил нэрээр нэрлэсэн согтууруулах ундаа үйлдвэрлэх;

14<sup>2</sup>.1.4..согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, экспорт эрхэлдэг, согтууруулах ундаа борлуулдаг хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүнийг сурталчлах, нэрийг нь олон нийтэд таниулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор соёл, урлаг, спортын болон бусад олон нийтийн арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх;

14<sup>2</sup>.1.5.эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр тэмдэг хэрэглэх;

14<sup>2</sup>.1.6.согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээний талаар төрөл бүрийн сугалаа, хонжвор, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа явуулах.

14<sup>2</sup>.2.Согтууруулах ундааны зар сурталчилгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

14<sup>2</sup>.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг сурталчилгааг ивээн тэтгэж болно.

14<sup>2</sup>.4.Согтууруулах ундаагаар үйлчилдэг байгууллагын гадна болон үйлчилгээний танхимд зурагт хуудас, аливаа бусад хэлбэрээр согтууруулах ундаа сурталчлахыг хориглоно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 14<sup>1</sup> зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны . . . дугаар сарын . . . –ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ГАРЫН ҮСЭГ



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20.. оны . . . дугаар

Улаанбаатар

сарын . . . -ны өдөр

хот

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 5 дахь заалтын “пиво” гэснийг “шар айраг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг ..... эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**